

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны
...12... дугаар сарын ...27...-ны өдрийн А/401
дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27 А/401

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн
байгууллагын Мөрдөн байцаах тасаг, хэсэг

Албан тушаалын нэр:

Мөрдөгч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-7

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Нутаг дэвсгэрийн цагдаагийн
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан харьяалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах.

1. Харьяалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, гэмт хэрэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн байцаалтын ажиллагаа явуулах.

2. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар цагдаагийн бусад албадтай хамтран ажиллах.

3. Удирдлагаас өгсөн бусад үүргийг хэрэгжүүлэх.

4. Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны холбогдох журамд заасныг хэрэгжүүлэх; 1.2.Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах албаны даргын тушаалаар батлагдсан, дүрэм, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах.	Мөрдөн шалгах ажлын үр дүн дээшилж, гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт ахисан байна.	Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 229/-ыг хэрэгжүүлэх; 2.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх.	Хамтын ажлын уялдаа холбоо сайжирсан байна.	Г Г
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Удирдлагаас өгсөн үүргийг цаг тухайд нь биелүүлж, үр дүн биелэлтийг танилцуулах.	Ажлын гүйцэтгэл сайжирна.	Г
Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	4.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 4.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 4.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/	
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	Цагдаагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; -Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах;

		-Шаардлагатай асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх. -Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point програмуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх. -Нууц хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын Мөрдөн байцаах тасаг, хэсгийн дарга, чиглэлийн ахлах мөрдөгч, ахлах мөрдөгч нар

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;

Шууд бус харилцах байгууллага:

-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Байгууллагын нэр:
Шийдвэрийн огноо:
Дугаар:.....

Т.ГАНЗОРИГ

2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27 өдөр
Дугаар: 11401

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:
.....
.....

20... оны дугаар сарын-ны өдөр
--